МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 22 өдөр Дугаар А/601 Мөрөн сум

Отрын малчдыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан өвөлжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.3, 32.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/572 дугаар захирамжаар зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Жаргалант сумын Цагаан –Бургас, Хөнжил, Цэцүүх багт ажиллаж , үүссэн нөхцөл байдалтай газар дээр нь үзэж танилцаж зудын эрсдэлийн үнэлгээгээр Жаргалант сумын нутаг дэвсгэр 100% цасан бүрхүүлтэй, цасны зузаан 20-65 см, цасны нягт 0,2 г/куб,см, цасан дор 1-2 мм мөсөн бүрхүүл тогтсон, хөрийн зузаан 3-4 см, агаарын температур олон жилийн дунджаас 2,0-2,9 цельсийн хүйтэн, Жаргалант сумын аюулын үнэлгээ 8,0, эмзэг байдлын үнэлгээ 5,3, чадавхын үнэлгээ 4,3 тус тус гарч эрсдэлийн үнэлгээ 8,8 буюу их эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарч, ажлын хэсэг ажилласнаас хойш 11 дүгээр сарын 14-ны өдөр дахин цас орж 2,9 мм хур тунадас унасан ба цасны зузаан сумын төв орчимдоо 3-4 см-ээр нэмэгдэж, Той, Цэцүүх багуудад өмнөх байсан цасны зузаан 5-10 см-ээр нэмэгдсэн ба Ус, цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар зудын нэн эрсдэлтэй суманд орсон тул тус сумаас Төмөрбулаг, Галт, Шинэ-Идэр, Түнэл, Мөрөн, Тосонцэнгэл, Арбулаг, Бүрэнтогтох, Тариалан, Алаг-Эрдэнэ, Эрдэнэбулган нийт 11 суманд 85 өрхийн 52882 толгой мал отрын замд гараад байгаа тул Жаргалант болон бусад сумаас очиж буй отор нүүдлийг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан өвөлжүүлж, хаваржуулах, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тусламж үйлчилгээнд хамруулж ажиллахыг дээрх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Сумдаас отор нүүдэл хийж буй өрхүүдэд тулгамдаж буй асуудлыг хүлээн авч, хууль тогтоомжийн хүрээнд хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажиллахыг аймгийн Онцгой комисс, шуурхай штабын дарга бөгөөд Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Осох)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

d/zahiramj

6712011402